



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Гарын үсэг зурах эрх олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.8 дахь заалт, Сангийн сайдын 2016 оны “Журам шинэчлэн батлах тухай” 415 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний баримт бичигт /тушаал шийдвэр, гэрээ, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, их засварын ажил, тоног төхөөрөмж хүлээн авах комисс, барилга угсралтын ажил хүлээн авах Улсын комиссын акт/-д гарын үсэг зурах албан тушаалтныг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Ганцэцэг/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Б.Баярт/-т даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ



Эрүүл мэндийн сайдын  
2018 оны 02 сарын 14-ны өдрийн  
АББ дугаар тушаалын хавсралт



### Гарын үсэг зурах албан тушаалтан

1. Барилга, их засварын ажлын гүйцэтгэлд:  
Батлав. Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга  
Гарын үсэг:
  - Хуулийн хэлтсийн дарга
  - Салбарын ерөнхий санхүүч
  - Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
2. Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний гэрээ:  
Батлав. Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга  
Гарын үсэг:
  - Хуулийн хэлтсийн дарга
  - Салбарын ерөнхий санхүүч
  - Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
  - Хуулийн хэлтсийн мэргэжилтэн
3. Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний холбогдох тушаалын төсөл:  
**САЙДЫН ТУШААЛ**  
Гарын үсэг:
  - Төрийн нарийн бичгийн дарга
  - Бодлого, төлөвлөлтийн газрын дарга
  - Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
  - Хуулийн хэлтсийн дарга
  - Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
4. Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний холбогдох тушаалын төсөл:  
**ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ТУШААЛ**  
Гарын үсэг:
  - Бодлого, төлөвлөлтийн газрын дарга
  - Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
  - Хуулийн хэлтсийн дарга
  - Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
5. "Их засвар, тоног төхөөрөмж хүлээн авах комисс, барилга угсралтын ажил хүлээн авах Улсын комиссын акт"-гарын үсэг зурах  
Гарын үсэг:
  - Хуулийн хэлтсийн дарга
  - Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
  - Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
6. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гэрээ, гүйцэтгэлд гарын үсэг зурах  
Батлав. Төрийн нарийн бичгийн дарга  
Гарын үсэг:
  - Бодлого, төлөвлөлтийн газрын дарга
  - Хуулийн хэлтсийн дарга
  - Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
  - Салбарын ерөнхий санхүүч
  - Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
  - Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн